



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 445

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 112,924,800.00 (нэг зуун арван хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтамир, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Батсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээд (Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар)-д эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001455

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
3 дугаар тогтоолын хавсралт



**“МИАТ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг цаашид ашиглах
жил, үнийг шинэчлэн тогтоож Хэнтий аймгийн Өмчийн газарт
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
1	Ланд круйзер-200 маркийн, 07-87 УБО улсын дугаартай суудлын автомашин	2011/2011	112,924,800.00	33,877,440.00	3 жил
Нийт хөрөнгийн дүн			112,924,800.00 (нэг зуун арван хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга найман зуун)	33,877,440.00 (гучин гурван сая найман зуун далан долоон мянга дөрвөн зуун дөчин)	